



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/153

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг  
шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 60 дугаар зүйлийн 60.1.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.7 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол шинжлэх ухааны газрын дүгнэлтийг үндэслэн Бор-Өндөр сумын Бор-Өндөр цогцолбор сургуулийн ангилалд өөрчлөлт оруулан дунд, ахлах ангийн сургалтын үйл ажиллагааг явуулахаар өөрчилж, Бор-Өндөр бага сургуулийг шинээр байгуулахаар болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг тус тус шинээр олгосугай.

2.2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн “Нэр өөрчлөх тухай” А/24 дүгээр захирамжийн хавсралтад дурдсан Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Ерөнхий боловсролын Бор-Өндөр цогцолбор сургууль гэсэн нэршлийг хүчингүй болгосугай.

3.Өөрчлөлтийн талаарх мэдээллийг тус сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлд тэмдэглэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ